

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ч.ЭРДЭНЭБААТАРЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011.03.17

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр нь 6 үндсэн зорилт, 111 заалт, 245 хэрэгжүүлэх арга хэмжээнээс бүрдэж байна. Хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилт 48.8 хувь, Боловсрол, соёл урлаг, спортын талаар хэрэгжүүлэх зорилт 62.4 хувь, Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн салбарын чиглэлээр хэрэгжүүлэх зорилт 57,8 хувь, төрийн байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэх зорилт 60,0 хувь, Дэд бүтэц, үйлдвэрлэлийг хөгжүүлэх эдийн засгийн өсөлтийг хангах зорилт 62,4 хувь, Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны хөгжлийг хангах зорилт 64,1 хувийн биелэлттэй, нийт дундаж хувь нь 59,7 хувь буюу 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай харьцуулан дүгнэвэл 5,0 оноотой байна.

Аймгийн хэмжээнд 2010 онд дараах онцлох үйл ажиллагаа хийгдсэн байна. Үүнд:

1. Хэнтий аймаг орон нутгийн төсвийн хувьд бие даан санхүүжиж, Монгол улсын “Нэгдсэн төсвийн тухай” хуулийн дагуу 2009 онд орон нутгийн төсвийн зарлагаас давсан 470,8 сая төгрөг, 2010 онд 358,5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.
2. Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолоор баталсан “Ил тод байдлыг хангах” тухай тогтоолын дагуу бүх сум, албан байгууллагууд “Шударга, ил тод төрийн байгууллага” нэртэй самбар гаргаж байгууллагын төсөв санхүү, аудит, МХГ, ХШҮ-ний дүнг ил тод тавьж, олон нийтэд мэдээлдэг болсон.
3. Хэнтий аймаг 2010 оныг “Багийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, энэ ажлын хүрээнд сум, багт зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг авч, багуудыг тохижуулахад зориулан хөдөөгийн бүх багт 2,0 сая төгрөг, төвийн багуудад 1,0 сая төгрөг олгосныг багууд төвдөө засвар хийх, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулаад байна. Аймгийн 83 багт нийт 595,2 сая төгрөгийн төсөв батлагдаж багийн Засаг даргын хяналтаар цалин, тээвэр шатахуун, хэвлэл, томилолтын зардалд зарцууллаа. Багийн Засаг дарга нарын тавьсан хүсэлтийн дагуу 83 багийн даргыг 270,0 мянган төгрөгийн үнэ бүхий зургийн аппаратаар, аймгийн төвийн 7 багаас бусад бүх баг буюу 76 багийн Засаг даргад тус бүр нь 950,0 мянган төгрөгийн үнэ бүхий мотоцикль өгч унаажууллаа.
4. 2010 онд “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийн үйл ажиллагаа тогтмолжиж иргэдийн талархлыг хүлээн, давхардсан тоогоор 31334 иргэн нэг цонхноос төрийн

үйлчилгээг хүртсэн байна. Энэ хугацаанд “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвөөс холбогдох үйлчилгээ авахад бүрдүүлэх материал, хэдий хугацаанд үйлчилгээг авч болох хуулийн заалт, дүрэм журам, зааврын талаар тайлбар мэдээлэл 1469 иргэнд өгч, үйлчилгээний талаарх саналт хүсэлт, тэдний шинэ санаа санаачилгыг дэмжин үйл ажиллагаандаа тусган авч ажиллах зорилгоор 824 иргэнээс санал авч, Хүний аюулгүй байдлын судалгааны төв болон “Нэг цонхны үйлчилгээ”-ний төсөл хэрэгжүүлэгч байгууллагад уламжлан хамтарч ажиллалаа.

5. Хэнтий аймаг 2010 онд нийт 32 тэрбум 821 сая төгрөгийн хөрөнгө оруулалт оруулж бүтээн байгуулалтын ажил өрнүүллээ. Энэ нь өмнөх оныхоос хоёр дахин өссөн үзүүлэлттэй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалт – 20 тэрбум, **орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 1 тэрбум**, төсөл хөтөлбөрийнх 2,4 тэрбум, хувийн хэвшлийнхэн 9,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийлээ.
6. “Их хааны өлгий- Хан Хэнтий нутаг” сэдэвт аялал жуулчлалын зөвлөлгөөнийг Тэмүжинг Хамаг монголын ханд өргөмжилсөн Цэнхэрмандал сумын “Хар зүрхний Хөх нуур”-ын эрэг дээрх жуулчны баазад зохион байгууллаа. Их эзэн Чингис хааны түүхтэй холбогдолтой газруудыг сурталчлах, тэдгээрийг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчид, мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах зорилго агуулсан энэ зөвлөлгөөнийг аймгийн Засаг даргын тамгын газар, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран зохион байгуулснаар “Чингисийн өлгий нутаг” гэсэн дэлхийд өөр хаа ч байхгүй аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнээ зах зээлийн тавцанд гаргах нэгэн чухал алхам болсон байна.
7. Аймгийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас 2010 онд 650 сая төгрөгийн зээлийг ХААН банкаар дамжуулан 20 төсөлд, ХАС банкаар 2009 онд олгосон зээлийн эргэн төлөлтөөс 7 төсөлд 166 сая төгрөгийн зээл олгож, эдгээр хөнгөлттэй зээлийн үр дүнд 23 үйлдвэрлэл шинээр байгуулагдан, 57 үйлдвэрлэл үйл ажиллагаагаа өргөтгөн сэргэж, шинээр 242 ажлын байр нэмэгдэн, 152 ажлын байр хадгалагдан үлдэх боломжийг бий болгожээ. Шинээр цэвэр усны, хиам, вакуум цонх, полистрол тоосго, гурил, талх, сүү, нарийн боов, төмөр дээвэр, хэвлэлийн, эсгий, гутал, оёдол, гэрийн модон эдлэлийн үйлдвэрлэл, зөгий, фермерийн аж ахуйнууд байгуулагдан ажиллаж байна.
8. Бизнесийн орчныг сайжруулах алхам хийсэн байна. 2009-2010 онд улс орон нутаг, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр хийх барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт холбогдох хуулийн “орон нутгийн давуу эрх олгох” тухай заалтыг хэрэглэн аймаг орон нутгийнхаа аж ахуйн нэгжүүдийг

дэмжих бодлого барьж ажилласны үр дүнд энэ онд хийгдсэн зам, барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэгчийн болон тоног төхөөрөмж бараа материал нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулинд заасны дагуу орон нутгийн давуу эрх олгож ажилласнаар энэ жил нийт 59 худалдан авах ажиллагаа зохион байгуулсны 70%-ийг орон нутгийн аж ахуйн нэгжүүд тендерт шалгарч хэрэгжүүлсэн байна.

9. 2010 онд улсын төсөв, төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр нийгмийн салбарт аймгийн хэмжээнд нийт 8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж үйлчилгээний чанарыг сайжруулах нөхцөл боломж бүрдлээ. Энэ нь аймгийн нийт хөрөнгө оруулалтын 37 хувийг эзэлж байна.

Аймгийн ИТХ-ын Тавдугаар хуралдаанаар “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2010 оны хэрэгжилтийн тухай тайлан”-г хэлэлцээд, Засаг дарга Ч.Эрдэнэбаатар нь бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулан, хөдөө аж ахуй, дэд бүтцээ хөгжүүлэх, байгаль орчноо хамгаалах, хүн амд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, хууль ёсыг бэхжүүлж, нийгмийн дэг журам, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч ажилласны зэрэгцээ аймгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэхийн тулд гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Хэнтий аймаг нь Монгол улсынхаа хэмжээнд аялал жуулчлалын онцгой чухал бүс нутаг гэдгийг дотооддоо төдийгүй гаднын улс орнуудад сурталчлан таниулахад идэвх санаачлагатай ажилласныг тэмдэглээд үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2010 оны хэрэгжилтийг “Хангалттай сайн хэрэгжсэн” гэж дүгнэсэн байна.

Энэхүү үнэлгээ нь бидний хийсэн хяналт шинжилгээний үнэлгээтэй нийцэж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ